



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2018 оны 5 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|-----------|--|
| Дарга | -Гадаад харилцааны сайд. |
| Дэд дарга | -Зам, тээврийн хөгжлийн дэд сайд. |
| Гишүүд: | -Шадар сайдын ажлын албаны дарга;
-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал;
-Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал;
-Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга ;
-Нийслэлийн Засаг даргын Гэр хороолол, хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
-Үндэсний хөгжлийн газрын дарга;
-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга;
-Гаалийн ерөнхий газрын дэд дарга; |

-Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга;

-Татварын ерөнхий газрын дэд дарга;

-“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан орлогч дарга;

-Монголын тээвэр, зуучлагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

-Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн явцын талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Ажлын хэсгийн дарга (Д.Цогтбаатар)-т даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ